

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: БӨА-2022/01/НА-СТА-НТГ

Цахим хуудас: www.audit.mn

Баян-Өлгий аймаг.

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazguld @ audit.gov.mn

Агуулга

| | |
|---|-----------|
| Товчилсон үгийн тайлбар | 3 |
| Хүснэгт, график, хавсралтын товъёог | 4 |
| Дүрслэлийн товъёог | 4 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 1.ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ | 6 |
| 1.1 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт | 6 |
| 1.1.1 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлтийн талаар..... | 6 |
| 1.1.2 Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөлтийн талаар | 10 |
| 1.2 Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн нийт орлого, зарлагын төлөвлөлт | 11 |
| 1.2.1 Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт орлогын төлөвлөлтийн талаар | 11 |
| 1.2.2 Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагын төлөвлөлтийн талаар | 13 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн төлөвлөлт | 15 |
| 2. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ | 18 |
| 2.1 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын гүйцэтгэл..... | 18 |
| 2.1.1 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэлийн талаар | 18 |
| 2.2 Аймгийн Орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар. 22 | |
| 2.2.1 Орон нутгийн нийт төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар..... | 22 |
| 2.2.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар | 23 |
| 2.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн талаар | 26 |
| 2.2.4 Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийн талаар..... | 27 |
| 2.2.5 Аймгийн ТЕЗ-ийн орон тооны гүйцэтгэлийн талаар | 28 |
| 2.3 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар | 29 |
| 3. ТЕЗ-ИЙН 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН | 31 |
| 3.1 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний төлөвлөлт | 31 |
| 3.2 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилт | 32 |
| ДҮГНЭЛТ: | 34 |
| ЗӨВЛӨМЖ:..... | 35 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|------------|---|
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХХОАТатвар | Хувь хүний орлогын албан татвар |
| АТБӨЯХТ | Авто тээвэр болон өөрөө явах хэрэгсэлийн татвар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| БОХСан | Байгаль орчныг хамгаалах сан |
| ГБХЗХ | Гэр бүл |
| ГХБХБГ | Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газар |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ЕБ | Ерөнхий боловсрол |
| БОХС | Байгаль орчныг хамгаалах сан |
| ХТА | Хот тохижуулах алба |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |

Хүснэгт, график, хавсралтын товъёог

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-------------|---|-----------------|
| Хүснэгт №1 | Орон нутгийн төсвийн төлөвлөлт | 6-7 |
| Хүснэгт №2 | Баян-Өлгий аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт | 8 |
| Хүснэгт №3 | Татварын хэлтэс болон сумуудын 2021 оны орон нутгийн орлогын төлөвлөлт | 9 |
| Хүснэгт №4 | Орон нутгийн орлогын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулсан судалгаа | 9 |
| Хүснэгт №5 | Орон нутгийн суурь зарлагын төлөвлөгөө | 10 |
| Хүснэгт №6 | Төсвийн нийт орлогын анх баталсан болон тодотгосон төлөвлөгөө | 12 |
| Хүснэгт №7 | Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нийт зарлагын төлөвлөлт | 14 |
| Хүснэгт №8 | Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт | 15 |
| Хүснэгт №9 | Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2021 оны төлөвлөгөө | 16 |
| Хүснэгт №10 | Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт | 17 |
| Хүснэгт №11 | Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл /орлогын төрлөөр/ | 18 |
| Хүснэгт №12 | Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл /сумаар/ | 19-20 |
| Хүснэгт №13 | Орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл | 20-21 |
| Хүснэгт №14 | Гүйцэтгэлийг байгууллагын төрлөөр ангилж үзэхэд | 21 |
| Хүснэгт №15 | Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт | 22 |
| Хүснэгт №16 | Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн орлогын бүтэц | 22 |
| Хүснэгт №17 | Нийт төсвийн зарлагын гүйцэтгэл | 24 |
| Хүснэгт №18 | Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгуулаар харуулбал | 25 |
| Хүснэгт №19 | Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл | 26-27 |
| Хүснэгт №20 | Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэл | 27-28 |
| Хүснэгт №21 | Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл | 28 |
| Хүснэгт №22 | Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл | 29-30 |

Дүрслэлийн товъёог

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|------------|---|-----------------|
| Дүрслэл №1 | Төсвийн суурь зарлагын төлөвлөлтийн бүтэц | 11 |
| Дүрслэл №2 | Төсвийн нийт зарлагын төлөвлөлтийн бүтэц | 15 |
| Дүрслэл №3 | Суурь орлогын гүйцэтгэл/аймаг, сумаар/ | 19 |

Хавсралтын товъёог

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---------|-----------------|
|---|---------|-----------------|

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилт: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэж тайлагнасан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл
- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аудитын хамрах хүрээ: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсөв болон улсын төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн аймгийн ИТХ-аас баталсан 2021 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтсээс ирүүлсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн тайлан, мэдээ, судалгаа, бусад холбогдох мэдээлэл, баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, 6817-6:2020, 6817-8:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн бөгөөд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтсээс тайлан, судалгаа авах, тоон мэдээлэл авах, нэгтгэл судалгаа хийх, тулган баталгаажуулах, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 20-ныг хүртэл хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,228.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

1.ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт

Аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас 4,901.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

1.1.1 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлтийн талаар

Орон нутгийн төсвийн суурь орлогыг 23,537.4 сая төгрөгөөр тодотгож төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 5,740.5 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 7,959.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс суурь зарлагад олгох шилжүүлгийг 358.6 сая төгрөгөөр баталжээ.

Сангийн яамнаас тус аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 11,156.4 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Хүснэгт№1

Орон нутгийн төсвийн төлөвлөлт

сая төгрөгөөр

| № | Үзүүлэлт | Баян-Өлгий аймаг | | | | | Анх батлагдсан дүнгээс /өссөн, буурсан/ |
|-----------|---|------------------------------------|---|---|---|---|---|
| | | Сангийн яамны хянасан дүн | 2021 он | | | Аймгийн ОНО-ын төсөв | |
| А | Б | 1 | Анх батлагдсан | Тодотгол -1 | Тодотгол -2 | 4 | 6 |
| | ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар | МУ-ын 2021 оны төсвийн тухай хууль | Аймгийн ИТХ-ын 2020 оны 16 дугаар тогтоол | Аймгийн ИТХ-ын 2021 оны 24, 34 дүгээр тогтоол | Аймгийн ИТХ-ын 2021 оны 41 дүгээр тогтоол | Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсаныг нэмдсэн дүнгээр | /4-2/ |
| I | ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО | 19,116.2 | 19,798.2 | 20,136.2 | 20,550.9 | 23,537.4 | 3,739.2 |
| | НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 19,116.2 | 19,798.2 | 20,136.2 | 20,550.9 | 23,537.4 | 3,739.2 |
| | УРСГАЛ ОРЛОГО | 11,156.4 | 11,838.4 | 11,838.4 | 11,852.6 | 12,059.2 | 220.8 |
| | ТАТВАРЫН ОРЛОГО | 10,322.0 | 10,642.0 | 10,642.0 | 10,671.2 | 10,808.5 | 166.5 |
| | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 834.4 | 1,196.4 | 1,196.4 | 1,181.4 | 1,250.7 | 54.3 |
| | ТӨСВИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ | | | | | 236.3 | 236.3 |
| | ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ | | | 338.0 | 338.0 | 1,542.2 | 1,542.2 |
| | СУМДЫН ТУСГАЙ САНГУУД | 7,959.8 | 7,959.8 | 7,959.8 | 8,360.3 | 9,699.7 | 1,739.9 |
| II | ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА | 24,856.7 | 25,538.7 | 25,876.7 | 27,002.7 | 29,989.2 | 4,450.5 |
| | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 24,856.7 | 25,538.7 | 25,876.7 | 27,002.7 | 29,989.2 | 4,450.5 |
| | УРСГАЛ ЗАРДАЛ | 17,255.5 | 17,937.5 | 18,275.5 | 19,001.0 | 21,472.8 | 3,535.3 |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ | 16,640.6 | 17,336.9 | 17,674.9 | 18,394.6 | 20,866.4 | 3,529.5 |

| | | | | | | | |
|-----|----------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| | ЗАРДАЛ | | | | | | |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 614.9 | 600.6 | 600.6 | 606.4 | 606.4 | 5.8 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,601.2 | 7,601.2 | 7,601.2 | 8,001.7 | 8,516.4 | 915.2 |
| | УРСГАЛ ТЭНЦЭЛ | -6,099.1 | -6,099.1 | -6,437.1 | -7,148.4 | -9,413.6 | -3,314.5 |
| III | НИЙТ ТЭНЦЭЛ | -5,740.5 | -5,740.5 | -5,740.5 | -6,451.8 | -6,451.8 | -711.3 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн 7,959.8 сая төгрөгийг нэмж тооцоход Сангийн яамны хянасан тус аймгийн ТЕЗ-ийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 19,116.2 сая, орон нутгийн төсвийн суурь зарлага 24,856.7 сая төгрөг байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” ээлжит II дугаар хуралдааны 16 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 682.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 19,798.2 сая төгрөгөөр, суурь зарлагыг 25,538.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлыг батлах тухай” ээлжит III дугаар хуралдааны 24 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөгөөг 338.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 6,451.8 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 8,360.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” ээлжит V дугаар хуралдааны 41 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 20,550.9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 27,002.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн суурь орлогыг 206.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөснийг нэмж тооцоход аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 12,059.2 сая төгрөг байна.

Сумуудын давсан орлого буюу урьд оны үлдэгдлээс санхүүжих орлогыг 689.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнг 514.7 сая төгрөгөөр төлөвлөснийг нэмж тооцоход урьд оны үлдэгдлээс санхүүжих орлого 1542.2 сая төгрөг, төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих орлого 236.3 сая төгрөг байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 1,339.4 сая төгрөг байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны суурь орлогын төлөвлөгөө 23,537.4 сая, суурь зарлагын төлөвлөгөө 29,989.2 сая төгрөг, нийт тэнцэл буюу улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 6,451.8 сая төгрөг байна.

Хүснэгт №2 Баян-Өлгий аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт

сая төгрөгөөр

| Орлогын төрөл | Сангийн яамны хянасан | Аймгийн ИТХ-ын баталсан | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд орсон | Тодотгол /Аймгийн ИТХ-ын 2021.08.09-ний №41 тоот тогтоол/ | Сумын ИТХ-аар баталсан ыг нэмсэн дүнгээр | 2021 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө | Зөрүү | |
|--|-----------------------|-------------------------|--|---|--|--|--------------|--------------|
| | | | | | | | /e-b/ | /e-a/ |
| СУУРЬ ОРЛОГО | 11,156.4 | 11,838.4 | 11,852.6 | 11,852.6 | 12,059.3 | 12,059.3 | 220.9 | 902.9 |
| УРСГАЛ ОРЛОГО | 11,156.4 | 11,838.4 | 11,852.6 | 11,852.6 | 12,059.3 | 12,059.3 | 220.9 | 902.9 |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 10,322.0 | 10,642.0 | 10,671.2 | 10,671.2 | 10,808.6 | 10,808.6 | 166.6 | 486.6 |
| Орлогын албан татвар | 8,280.0 | 8,530.0 | 8,559.2 | 8,559.2 | 8,632.6 | 8,632.6 | 102.6 | 352.6 |
| ХАОАТатвар | 8,280.0 | 8,530.0 | 8,559.2 | 8,559.2 | 8,632.6 | 8,632.6 | 102.6 | 352.6 |
| татвар | 7,200.0 | 7,300.0 | 7,339.6 | 7,339.6 | 7,347.2 | 7,347.2 | 47.2 | 147.20 |
| Үйл ажиллагааны орлого | 610.0 | 610.0 | 610.0 | 610.0 | 615.4 | 615.4 | 5.4 | 5.40 |
| Хөрөнгийн орлого | 1,400.0 | 1,400.0 | 1,400.0 | 1,400.0 | 1,466.0 | 1,466.0 | 66.0 | 66.00 |
| Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар | 70.0 | 70.0 | 70.0 | 70.0 | 72.0 | 72.0 | 2.0 | 2.00 |
| ХХОАТатварын буцаан олголт | (1,000.0) | (850.0) | (860.4) | (860.4) | (868.0) | (868.0) | (18.0) | 132.00 |
| Хөрөнгийн татвар | 777.0 | 797.0 | 797.0 | 797.0 | 800.5 | 800.5 | 3.5 | 23.5 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 340.0 | 340.0 | 340.0 | 340.0 | 340.0 | 340.0 | - | - |
| Бууны албан татвар | 57.0 | 57.0 | 57.0 | 57.0 | 60.5 | 60.5 | 3.5 | 3.50 |
| АТӨЯХАТатвар | 380.0 | 400.0 | 400.0 | 400.0 | 400.0 | 400.0 | - | 20.00 |
| Бусад татвар | 365.0 | 365.0 | 365.0 | 365.0 | 385.5 | 385.5 | 20.5 | 20.5 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 330.0 | 330.0 | 330.0 | 330.0 | 332.0 | 332.0 | 2.0 | 2.00 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 | 44.5 | 44.5 | 14.5 | 14.50 |
| Хог хягдалын үйлчилгээний хураамж | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 9.0 | 9.0 | 4.0 | 4.00 |
| Газрын төлбөр | 200.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 252.0 | 252.0 | 2.0 | 52.0 |
| Газрын төлбөр | 200.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 252.0 | 252.0 | 2.0 | 52.00 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 700.0 | 700.0 | 700.0 | 700.0 | 738.0 | 738.0 | 38.0 | 38.0 |
| Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 | 31.0 | 31.0 | 1.0 | 1.00 |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 650.0 | 650.0 | 650.0 | 650.0 | 687.0 | 687.0 | 37.0 | 37.00 |
| Ус, рашаан ашигласны төлбөр | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | - | - |
| II.Татварын бус орлого | 834.4 | 1,196.4 | 1,181.4 | 1,181.4 | 1,250.7 | 1,250.7 | 54.3 | 416.3 |
| Хүүгийн орлого | | | | | 23.4 | 23.4 | 23.4 | 23.40 |
| Торгуулийн орлого | 380.0 | 480.0 | 480.0 | 480.0 | 493.6 | 493.6 | 13.6 | 113.60 |
| Төсөвт газрын өөрийн орлого | 54.4 | 101.4 | 86.4 | 86.4 | 86.4 | 86.4 | (15.0) | 32.00 |
| Бусад нэр заагдаагүй орлого | 400.0 | 455.0 | 455.0 | 455.0 | 455.0 | 455.0 | - | 55.00 |
| Хүлээгдэж буй орлого | | 160.0 | 160.0 | 160.0 | 192.3 | 192.3 | 32.3 | 192.30 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдааны “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор аймаг, сумын татварын болон татварын бус орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 682.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,838.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөнд Улсын Их Хурлын тогтоолоор 1 удаа, аймгийн ИТХ-ын тогтоолоор 1 удаа тодотгол хийгдэж өөрчлөлт орсон байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж баталсан дүнг оруулж тооцоход аймгийн 2021 оны төсвийн суурь орлогын төлөвлөгөө Сангийн яамны хянасан дүнгээс 902.9 сая төгрөгөөр нэмэгдэж 12,059.3 сая төгрөг болсон байна. Үүнээс: 10,808.6 сая төгрөгийг татварын орлогоос, 1,250.7 сая төгрөгийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №3 Татварын хэлтэс болон сумуудын 2021 оны орон нутгийн орлогын төлөвлөлт

сая төгрөгөөр

| № | Сумын нэр | 2020 он | | |
|----|---------------------|-----------------|-----------------------|--------------|
| | | Анх баталсан | Тодотгосон төлөвлөгөө | зөрүү |
| 1 | Алтай | 143.9 | 154.2 | 10.3 |
| 2 | Алтанцөгц | 34.7 | 34.7 | 0.0 |
| 3 | Баяннуур | 70.6 | 102.9 | 32.3 |
| 4 | Бугат | 101.3 | 101.3 | 0.0 |
| 5 | Булган | 212.9 | 212.9 | 0.0 |
| 6 | Буянт | 112.3 | 129.1 | 16.8 |
| 7 | Дэлүүн | 219.3 | 219.3 | 0.0 |
| 8 | Ногооннуур | 147.0 | 154.6 | 7.6 |
| 9 | Сагсай | 67.6 | 67.6 | 0.0 |
| 10 | Толбо | 112.3 | 127.6 | 15.3 |
| 11 | Улаанхус | 166.6 | 211.6 | 45.0 |
| 12 | Цэнгэл | 112.0 | 174.3 | 62.3 |
| 13 | Цагааннуур | 53.7 | 53.7 | 0.0 |
| 14 | Өлгий | 1,586.9 | 1,604.1 | 17.2 |
| 15 | Татварын хэлтэс | 8,697.4 | 8,711.5 | 14.1 |
| | БҮГД | 11,838.5 | 12,059.3 | 220.8 |
| | Аймгийн дүн | 8,697.4 | 8,711.5 | 14.1 |
| | Сумуудын дүн | 3,141.1 | 3,347.7 | 206.6 |

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн СТСХ-ийн 2021 оны төсвийн төслийн танилцуулга, мэдээлэл

Аймгийн ИТХ-ын баталсан төлөвлөгөөнөөс орон нутгийн орлогын төлөвлөгөөг аймгийн төлөвлөгөөг 14.1 сая төгрөгөөр, Алтай, Баяннуур, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумуудын төлөвлөгөөг нийт 206.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад:

Хүснэгт №4 Орон нутгийн орлогын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулсан судалгаа

сая төгрөгөөр

| № | Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|-----------------------------|------------------|------------------|-----------------|
| 1 | Аймгийн төсөвт орох орлого | 7,769.90 | 8,711.50 | 941.60 |
| 2 | Сумуудын төсөвт орох орлого | 2,766.70 | 3,347.70 | 581.00 |
| | Нийт орлого | 10,536.60 | 12,059.20 | 1,522.60 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх онтой харьцуулахад орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 1,522.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс аймгийн төсөвт орох орлого 941.6 сая, сумуудын төсөвт орох орлого 581.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

1.1.2 Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөлтийн талаар

Аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас 5,132.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас тус аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг 16896.8 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг оруулж тооцоход аймгийн ТЭЗ-ийн 2021 оны төсвийн суурь зарлагын нийт төлөвлөгөө 24,856.4 сая төгрөг байна.

Хүснэгт №5 Орон нутгийн суурь зарлагын төлөвлөгөө

| Үзүүлэлт | Сангийн яамны хянасан | Анх баталсан | сая төгрөгөөр | |
|--|-----------------------|-----------------|---|-----------------|
| | | | Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор тодотгосон | Зөрүү |
| А | 1 | 2 | 3 | 1/3-2/ |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 29989.2 | 25538.7 | 29989.2 | 4450.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 21472.8 | 17937.5 | 21472.8 | 3535.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 20866.4 | 17336.9 | 20866.4 | 3529.5 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 8281.9 | 8173.9 | 8514.9 | 341 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1072.7 | 1051.9 | 1134.2 | 82.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5625.2 | 5584.9 | 5636.5 | 51.6 |
| Хангамж, бараа материалын зардал | 368.9 | 369 | 449.6 | 80.6 |
| Нормативт зардал | 191.8 | 191.8 | 192.1 | 0.3 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 160.7 | 144.9 | 164.2 | 19.3 |
| Томилолт, зочны зардал | 120.8 | 140.8 | 108 | -32.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 676.9 | 677 | 750.9 | 73.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,367.50 | 1002.7 | 3,870.20 | 2867.5 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 606.4 | 600.6 | 652.2 | 51.6 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,516.40 | 7,601.20 | 8,516.40 | 915.2 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 29989.2 | 25538.7 | 29989.2 | 4450.5 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27021.2 | 25437.3 | 27021.2 | 1583.9 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 18660.9 | 17477.7 | 18660.9 | 1183.2 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 8360.3 | 7959.6 | 8360.3 | 400.7 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 2,968.00 | 101.4 | 2,968.00 | 2,866.60 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1425.8 | 101.4 | 1425.8 | 1324.4 |
| Урьд оны үлдэгдлээс | 1542.2 | | 1542.2 | 1542.2 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Сангийн яамнаас хянасан суурь зарлагын төлөвлөгөөг 682.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.


Монгол Улсын Их хурлаас 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль”-д орсон өөрчлөлтөөр тус аймагт

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 400.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосоноор хөрөнгийн зардлын төлөвлөгөө нэмэгдсэн байна.

Аймаг, сумуудын ИТХ-ын тогтоолоор суурь зарлагын төлөвлөгөөг 4,450.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна.

Хөрөнгийн зардлыг 915.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,364.8 сая, цалин, хөлс, нэмэгдэл урамшилын зардлыг 108.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20.8 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 40.3 сая, эд, хогшил, урсгал засварын зардлыг 15.8 сая, урсгал шилжүүлгийг 5.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Дүрслэл№1 Төсвийн суурь зарлагын төлөвлөлтийн бүтэц



Суурь зарлагын төлөвлөгөөний бүтцийг авч үзвэл 70 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд, 28 хувийг хөрөнгийн зардалд, 2 хувийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.2 Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн нийт орлого, зарлагын төлөвлөлт

Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,228.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

1.2.1 Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт орлогын төлөвлөлтийн талаар

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн нийт орлого эх үүсвэрийн 97,715.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас тус аймгийн төсвийн суурь орлогыг 11,156.4 сая, улсын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 5,740.5 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 65,443.2 сая, Эрүүл мэндийн даатгалын

сангийн санхүүжилтийг 513.0 сая, аймгийн Орон нутгийн хөгжлийн санд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 7,601.2 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг 358.6 сая, нийт 90,812.9 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 16 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн суурь орлогыг 11,838.4 сая төгрөгөөр, улсын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 5,740.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг 358.6 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 65,443.2 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 513.0 сая төгрөгөөр, аймгийн Орон нутгийн хөгжлийн санд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 7,601.2 сая төгрөгөөр буюу нийт 91,494.9 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №6 Төсвийн нийт орлогын анх баталсан, тодотгосон төлөвлөгөө

сая төгрөгөөр

| Орлого, эх үүсвэрийн төрөл | 2020 оны нийт орлого, эх үүсвэр | 2021 оны | | | | | |
|---|---------------------------------|---------------------------|----------------------------------|--------------------------------------|---|------------------------------------|-------------------------------------|
| | | Сангийн яамны хянасан дүн | Аймгийн ИТХ-аас анх баталсан дүн | МУ-ын 2021 оны төсөвт орсон өөрчлөлт | Аймгийн ИТХ-ын 2021.08.09-ны 41-р тогтоолоор тодотгосон | Сумдын ИТХ-аар нэмэгдүүлж баталсан | Аймгийн 2021 оны орлогын төлөвлөгөө |
| Татварын орлого | 9776.5 | 10,322.0 | 10,642.0 | 10671.2 | 10671.2 | 10,808.5 | 10,808.5 |
| Татварын бус орлого | 760.2 | 834.4 | 1,196.4 | 1181.4 | 1181.4 | 1,250.7 | 1,250.7 |
| Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 7642.1 | 5,740.5 | 5,740.5 | 6451.8 | 6451.8 | 6,451.8 | 6,451.8 |
| Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг | 6333.3 | 7,959.8 | 7,959.8 | 8360.3 | 8360.3 | 8,360.3 | 8,360.3 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 67,832.0 | 65,443.2 | 65,443.2 | 67213.8 | 67213.8 | 67,213.8 | 67,213.8 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 444.9 | 513.0 | 513.0 | 513 | 513 | 513.0 | 513.0 |
| Төсвийн шилжих үлдэгдэл | 1240.5 | | | | | 236.3 | 236.3 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 2321.4 | | | | | 1,339.4 | 1,339.4 |
| Урьд оны үлдэгдлээс | 136.8 | | | | | 1,542.2 | 1,542.2 |
| Нийт орлогын дүн | 96487.7 | 90812.9 | 91494.9 | 94391.5 | 94391.5 | 97,715.9 | 97,715.9 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 711.3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 400.5 сая, нийт 1,111.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит V хуралдааны “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 41 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн суурь орлогыг 11,852.6 сая

төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 6,451.8 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг 358.6 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 67,213.8 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 513.0 сая төгрөгөөр, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 8,001.7 сая төгрөгөөр, нийтдээ 94,391.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна. Энэ нь анх баталсан төсвөөс 2,896.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны ээлжит II дугаар хуралдааны 24 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдэл 338.0 сая төгрөгөөс санхүүжүүлэх зардлын хуваарилалтыг баталж, аймгийн ИТХ-ын ээлжит III дугаар хуралдааны 34 дүгээр тогтоолоор уг хуваарилалтад өөрчлөлт оруулж дахин хуваарилсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсанаас 206.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх орлогыг 514.7 сая төгрөгөөр, давсан хэсгээс санхүүжих орлогыг 689.5 сая төгрөгөөр буюу урьд оны үлдэгдлээс санхүүжих орлогыг 1204.2 сая төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 1320.4 сая төгрөгөөр, Буянт, Дэлүүн, Сагсай, Толбо сумуудын Байгаль хамгаалах сангийн үндсэн үйл ажиллагааны орлогыг 14.5 сая, Буянт, Ногооннуур сумууд Соёлын төвийн өөрийн орлогыг 4.5 сая төгрөгөөр буюу үндсэн үйл ажиллагааны орлогыг 1339.4 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Төсвийн шилжих үлдэгдэл 236.3 сая төгрөгийг нэмж тооцоход аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нийт орлого, эх үүсвэрийг 97,715.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

1.2.2 Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагын төлөвлөлтийн талаар

Аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,228.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас тус аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 90,812.6 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 16 дугаар тогтоолоор аймгийн нийт төсвийн зарлагыг Сангийн яамны хянасан дүнгээс 682.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 91,494.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 41 дүгээр тогтоолоор тодотгосон төсөв, сумуудын ИТХ-ын тогтоолоор төлөвлөж баталсан дүнгээр аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 97,715.8 сая төгрөг байна.

Хүснэгт №7 Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нийт зарлагын төлөвлөлт

сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Сангийн ямны хянасан | Анх баталсан төлөвлөгөө | Тодотгосон төлөвлөгөө | Зөрүү | Зөрүү |
|--|----------------------------|-------------------------------|--------------------------|----------------|----------------|
| А | 1 | 2 | 3 | /3-1/ | /3-2/ |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 90812.6 | 91494.9 | 97715.8 | 6903.2 | 6220.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 83211.4 | 83893.7 | 89199.4 | 5988.0 | 5305.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 79467.8 | 80164.3 | 85862.3 | 6394.5 | 5698.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 54729.7 | 55217.2 | 60,082.9 | 5,353.2 | 4865.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7388.8 | 7402.8 | 8,104.8 | 716.0 | 702.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5734.1 | 5584.9 | 5,625.2 | (108.9) | 40.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 845.1 | 861.3 | 1,444.9 | 599.8 | 583.6 |
| Нормативт зардал | 6409.5 | 6341.5 | 3,434.9 | (2,974.6) | -2906.6 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 102.8 | 144.9 | 686.0 | 583.2 | 541.1 |
| Томилолт, зочны зардал | 173.6 | 176.4 | 166.6 | (7.0) | -9.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 942.4 | 881.0 | 933.9 | (8.5) | 52.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3141.8 | 3554.3 | 5,383.1 | 2,241.3 | 1828.8 |
| ТАТААС | 1,678.2 | 1,678.2 | 1,348.6 | (329.6) | -329.6 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 1678.2 | 1678.2 | 1,348.6 | (329.6) | -329.6 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2065.4 | 2051.2 | 1,988.5 | (76.9) | (62.70) |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7601.2 | 7601.2 | 8,516.4 | 915.2 | 915.20 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 90812.6 | 91494.9 | 97715.9 | 6903.3 | 6221.0 |
| Улсын төсвөөс санхүүжих | 65443.2 | 65443.2 | 67213.8 | 1770.6 | 1770.6 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 65443.2 | 65443.2 | 67,213.8 | 1,770.6 | 1770.6 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24802.0 | 25437.3 | 27021.1 | 2219.1 | 1583.8 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 16842.4 | 17477.7 | 18,660.8 | 1,818.4 | 1183.1 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7959.6 | 7959.6 | 8,360.3 | 400.7 | 400.7 |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 513.0 | 513.0 | 513.0 | - | 0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 513.0 | 513.0 | 513.0 | - | 0.0 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 54.4 | 101.4 | 2,968.0 | 2,913.6 | 2,866.6 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 54.4 | 101.4 | 1,425.8 | 1,371.4 | 1324.4 |
| Урьд оны үлдэгдлээс | 0.0 | 0.0 | 1,542.2 | 1,542.2 | 1542.2 |


Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ТЕЗ-ийн тодотгосон нийт зарлагын төлөвлөгөө анх баталсан төлөвлөгөөнөөс 6,220.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Нормативт зардлыг анх баталсан төлөвлөгөөнөөс 2,906.6 сая, томилолт зочны зардлыг 9.8 сая, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 329.6 сая төгрөгөөр буюу нийт 3,246.0 сая төгрөгөөр бууруулж,

- Цалин, НДШ-ийн зардлыг 5,567.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 40.3 сая, хангамж, бараа материалын зардлыг 583.6 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 541.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардлыг 52.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,828.8 сая, хөрөнгийн зардлыг 915.2 сая төгрөгөөр буюу нийт 9,529.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож төлөвлөсөн байна.

Дүрслэл № 2 Төсвийн нийт зарлагын төлөвлөгөөний бүтэц



Нийт зарлагын төлөвлөгөөний бүтцийг авч үзвэл 88 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд, 9 хувийг хөрөнгийн зардалд, 1.3 хувийг татаас, 2 хувийг урсгал шилжүүлэгт төлөвлөсөн байна.

Хүснэгт № 8 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

| № | Үзүүлэлт | 2020 он | 2021 он | сая төгрөгөөр | |
|---|------------------------|-----------|-----------|---------------|--------|
| | | | | Зөрүү | Хувиар |
| 1 | Нийт орлого, эх үүсвэр | 96,487.70 | 97,715.80 | 1,228.10 | 101% |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан төсвийг өмнөх оны төсөвтэй харьцуулахад 1,228.1 сая төгрөгөөр буюу 1 хувиар нэмэгдсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн төлөвлөлт

Сангийн яамнаас тус аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг 65,443.4 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр 67,213.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн 67,213.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 513.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт №9 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2021 оны төлөвлөгөө сая төгрөгөөр

| Салбарын нэр | Анх баталсан төлөвлөгөө | | | Тодотгосон төлөвлөгөө | | |
|--|-------------------------|--------------|-----------------|-----------------------|--------------|-----------------|
| | ТЗШ | ЭМДС | Дүн | ТЗШ | ЭМДС | Дүн |
| Ерөнхий боловсролын сургууль | 39,158.1 | | 39,158.1 | 41,772.3 | | 41,772.3 |
| Сургуулийн өмнөх боловсрол | 16,795.9 | | 16,795.9 | 15,962.5 | | 15,962.5 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 8,812.7 | 513.0 | 9,325.7 | 8,812.7 | 513.0 | 9,325.7 |
| Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 447.1 | | 447.1 | 437.8 | | 437.8 |
| Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 229.6 | | 229.6 | 228.5 | | 228.5 |
| Нийт дүн | 65,443.4 | 513.0 | 65,956.4 | 67,213.8 | 513.0 | 67,726.8 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Төсвийн тодотголоор ТЗШ-ээс Ерөнхий боловсролын сургуулиудад олгох шилжүүлгийг 2,614.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад олгох шилжүүлгийг 833.4 сая төгрөгөөр, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төсвийг 9.3 сая, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийг 1.1 сая төгрөгөөр буюу нийтдээ 10.4 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн 62.1 хувийг боловсролын, 23.7 хувийг сургуулийн өмнөх боловсролын, 13.1 хувийг эрүүл мэндийн салбарын, 0.9 хувийг бусад салбарын төсөв эзэлж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 105.2 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

БШУСайд болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-ний дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 2021 оны эцэст өр төлбөргүй ажиллах, гэрээний биелэлтийг хангахад дэмжлэг хүссэж албан тоот хүргүүлсэн байна. БШУСайд 2021 оны 1а 5843 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь хэсэг, 14.2.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь хэсгийн дагуу мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг баримтлан тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг хөтөлбөр хооронд зохицуулалт хийхийг зөвшөөрч Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэгт “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” заалтын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27 ны өдрийн А/1093 дугаар захирамжаар орон нутгийн байгууллагуудын болон боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2021 оны төсөвт зохицуулалт хийж төсвийн хуваарийг баталсан байна.

Хүснэгт №10 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

сая төгрөгөөр

| Салбарын нэр | Төлөвлөгөө | | Зөрүү | Хувь |
|--|-----------------|-----------------|----------------|---------------|
| | 2020 он | 2021 он | | |
| Ерөнхий боловсролын сургууль | 44,935.4 | 41,772.3 | (3,163.1) | 92.96% |
| Сургуулийн өмнөх боловсрол | 16,498.9 | 15,962.5 | (536.4) | 96.75% |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 5,610.9 | 9,325.7 | 3,714.8 | 166.21% |
| Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 522.2 | 437.8 | (84.4) | 83.84% |
| Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 264.6 | 228.5 | (36.1) | 86.36% |
| Нийт дүн | 67,832.0 | 67,726.8 | (105.2) | 99.84% |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад:

- Эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөгөө 3,714.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь 2021 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой эрүүл мэндийн салбарын төсөв нэмэгдсэнээс гадна Дэлүүн, Ногооннуур, Цэнгэл сумуудын Сум дундын эмнэлгүүдийн статус өөрчлөгдөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа сумын Эрүүл мэндийн төв болсонтой холбоотой байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төлөвлөгөө 3,163.1 сая төгрөгөөр, сургуулийн өмнөх боловсролын төсөв 536.4 сая төгрөгөөр, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын төсөв 84.4 сая төгрөгөөр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын төсөв 36.1 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Тайлант онд Бугат сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, Өлгий сумын Хүүхдийн 22 дугаар цэцэрлэгүүд шинээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Бүлэг 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 1,345.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖЭЭ

2. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын гүйцэтгэл

2.1.1 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг 1,345.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ

Аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогоос нийтдээ 12,059.3 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13,404.8 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 11.2 хувиар буюу 1,345.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Татварын буцаан олголтыг нэмж тооцоход нийтдээ 14,272.8 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр нэгтгэн харуулбал:

Хүснэгт №11 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл /орлогын төрлөөр/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | сая төгрөгөөр Зөрүү | |
|--|-----------------|-----------------|------------------------|--------------|
| | | | дүнгээр | хувиар |
| НИЙТ ОРЛОГО | 12,059.3 | 13,404.8 | 1,345.5 | 111.2 |
| УРСГАЛ ОРЛОГО | 11,867.0 | 13,404.8 | 1,537.8 | 113.0 |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 10,808.5 | 11,932.4 | 1,123.9 | 110.4 |
| Орлогын албан татвар | 8,632.5 | 9,347.7 | 715.3 | 108.3 |
| ХАОАТатвар | 8,632.5 | 9,347.8 | 715.3 | 108.3 |
| Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар | 7,347.2 | 8,070.5 | 723.3 | 109.8 |
| Үйл ажиллагааны орлого | 615.4 | 575.4 | (40.0) | 93.5 |
| Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар | 72.0 | 229.1 | 157.1 | 318.1 |
| Хөрөнгийн орлого | 1,466.0 | 1,340.8 | (125.1) | 91.5 |
| ХХОАТатварын буцаан олголт | (868.0) | (868.0) | 0.0 | 100.0 |
| Өмчийн татвар | 400.5 | 311.1 | (89.4) | 77.7 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 340.0 | 262.6 | (77.4) | 77.2 |
| Бууны албан татвар | 60.5 | 48.5 | (12.0) | 80.2 |
| Дотоодын бараа, үйлчилгээний татвар | 400.0 | 466.1 | 66.1 | 116.5 |
| АТӨЯХАТатвар | 400.0 | 466.1 | 66.1 | 116.5 |
| Бусад татвар | 637.5 | 613.7 | (23.8) | 96.3 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 332.0 | 377.5 | 45.5 | 113.7 |
| Газрын төлбөр | 252.0 | 179.3 | (72.7) | 71.1 |
| Дуудлага худалдаа | - | 19.9 | 19.9 | |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 44.5 | 33.8 | (10.7) | 76.0 |
| Хог хягдалын үйлчилгээний хураамж | 9.0 | 3.3 | (5.7) | 36.9 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 738.04 | 1,193.77 | 455.7 | 161.7 |
| Ус, рашаан ашигласны төлбөр | 20.0 | 14.6 | (5.4) | 73.0 |
| Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр | 31.0 | 34.6 | 3.6 | 111.5 |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 687.0 | 1,144.6 | 457.6 | 166.6 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,058.4 | 1,472.4 | 414.0 | 139.1 |
| Хүүгийн орлого | 23.4 | 29.8 | 6.4 | 127.2 |
| Торгуулийн орлого | 493.6 | 584.5 | 90.9 | 118.4 |
| Төсөвт газрын өөрийн орлого | 86.4 | 88.1 | 1.7 | 101.9 |
| Бусад нэр заагдаагүй орлого | 455.0 | 770.0 | 315.0 | 169.2 |
| Хүлээгдэж буй орлого | 192.3 | | (192.3) | - |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 723.3 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 157.1 сая төгрөгөөр буюу 218.1 хувиар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 66.1 сая төгрөгөөр буюу 16.5 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 45.5 сая төгрөгөөр буюу 13.7 хувиар, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 3.6 сая төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 457.6 сая төгрөгөөр буюу 66.6 хувиар, татварын бус орлого 414 сая төгрөгөөр буюу 39.1 хувиар давж биелэгдсэн байна.
- Үйл ажиллагааны орлого 40.0 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар, хөрөнгийн орлого 125.1 сая төгрөгөөр буюу 8.5 хувиар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 77.4 сая төгрөгөөр буюу 22.8 хувиар, бууны албан татвар 12.0 сая төгрөгөөр буюу 19.8 хувиар, газрын төлбөр 72.7 сая төгрөгөөр буюу 28.9 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 10.7 сая төгрөгөөр буюу 24 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5.7 сая төгрөгөөр буюу 63.1 хувиар тасарсан байна.

Татварын бус орлогоос хүлээгдэж буй орлогоор төлөвлөсөн 192.3 сая төгрөгийн төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн суурь орлогын 68 хувийг буюу 9,106.7 сая төгрөгийг аймгийн төсвийн орлого, 32 хувийг буюу 4,298.1 сая төгрөгийг сумуудын төсвийн орлого эзэлж байна.

Дүрслэл №3 Суурь орлогын гүйцэтгэл/аймаг, сумаар/



Сумуудын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 950.4 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 395.2 сая төгрөгөөр буюу нийтдээ 1,345.6 сая төгрөгөөр давж биелэгджээ.

Хүснэгт №12 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл /сумаар/

| № | Сумын нэр | 2021 он | | | |
|---|-----------|------------|-----------|-------|-------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| 1 | Алтай | 154.2 | 255.4 | 101.2 | 165.7 |
| 2 | Алтанцөгц | 34.7 | 60.2 | 25.6 | 173.8 |

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

| | | | | | |
|--------------------|-----------------|-----------------|-----------------|----------------|--------------|
| 3 | Баяннуур | 102.9 | 86.7 | -16.2 | 84.3 |
| 4 | Бугат | 101.3 | 182.3 | 80.9 | 179.9 |
| 5 | Булган | 212.9 | 278.7 | 65.8 | 130.9 |
| 6 | Буянт | 129.1 | 176.7 | 47.6 | 136.9 |
| 7 | Дэлүүн | 219.3 | 251.6 | 32.3 | 114.7 |
| 8 | Ногооннуур | 154.6 | 273.9 | 119.3 | 177.2 |
| 9 | Сагсай | 67.6 | 285.9 | 218.3 | 422.7 |
| 10 | Толбо | 127.6 | 175.5 | 48.0 | 137.6 |
| 11 | Улаанхус | 211.6 | 233.2 | 21.7 | 110.2 |
| 12 | Цэнгэл | 174.3 | 243.0 | 68.7 | 139.4 |
| 13 | Цагааннуур | 53.7 | 47.2 | -6.5 | 87.9 |
| 14 | Өлгий | 1,604.1 | 1,747.8 | 143.7 | 109.0 |
| 15 | Татварын хэлтэс | 8,711.5 | 9,106.7 | 395.2 | 104.5 |
| БҮГД | | 12,059.3 | 13,404.8 | 1,345.6 | 111.2 |
| Сумын дүн | | 3,347.7 | 4,298.1 | 950.4 | 128.4 |
| Аймгийн дүн | | 8,711.5 | 9,106.7 | 395.2 | 104.5 |

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтэс 395.2 сая төгрөгөөр, 12 сум 972.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Баяннуур сум 16.2 сая төгрөгөөр, Цагааннуур тосгон 6.5 сая төгрөгөөр тасалсан байна.

2.1.2 Орон нутгийн төсвийн суурь зарлагын гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн байгууллагууд төлөвлөснөөс 1,811.8 сая төгрөгийн бага гүйцэтгэлтэй гарсан байна

Орон нутгийн төсвийн 2021 оны суурь зарлага нийтдээ 28,177.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвийн зарлагын эх үүсвэрийн хувьд орон нутгийн төсвөөс 19,603.4 сая төгрөгийг, Орон нутгийн хөгжлийн сангаас 8,360.3 сая төгрөгийг санхүүжүүлж, үйл ажиллагааны орлогоос 1,447.4 сая төгрөг бүрдүүлж, мөнгөний эхний үлдэгдлээс 914.9 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 2,127.4 сая төгрөгийн мөнгөний үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №13. Орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл

сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2021 он | | Зөрүү |
|--|------------------|-----------------|-----------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 29,989.20 | 28,177.4 | -1,811.8 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 29,989.20 | 28,177.4 | -1,811.8 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 20,820.61 | 19,994.3 | -826.3 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 8514.9 | 8437.9 | -77.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1134.2 | 1117.7 | -16.5 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5636.5 | 5604.9 | -31.6 |
| Хангамж, бараа материалын зардал | 449.6 | 448.2 | -1.4 |
| Нормативт зардал | 192.1 | 192.0 | -0.1 |

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

| | | | |
|--|------------------|-----------------|----------------|
| Эд хогшил, урсгал засварын зардал | 164.2 | 223.3 | 59.1 |
| Томилолт, зочны зардал | 108.0 | 105.7 | -2.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 750.9 | 748.5 | -2.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3870.2 | 3116.1 | -754.1 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 652.2 | 649.5 | -2.7 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,516.40 | 7533.6 | -982.8 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 29,989.20 | 29,389.9 | -599.3 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 27021.2 | 27,963.7 | 942.5 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 18660.9 | 19,603.4 | 942.5 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 8360.3 | 8,360.3 | 0.0 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 2,968.00 | 1,426.2 | -1541.8 |
| Мөнгөний эхний үлдэгдэл | | 914.9 | 914.9 |
| Мөнгөний эцсийн үлдэгдэл | | 2127.4 | 2127.4 |

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн зарлагын судалгаа

Төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 1,811.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн байгууллагууд 668.9 сая, сумуудын ИТХ 5.0 сая, ЗДТГ 42.4 сая, Соёлын төвүүд 7.2 сая, сумуудын ОНХСан 398.7 сая, Сум хөгжүүлэх сан 666.9 сая, Байгаль орчныг хамгаалах сан 5.8 сая, ТЗШ-ийн байгууллагууд тогтмол зардлын төлөвлөгөө 12.9 сая буюу нийт 1,811.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №14. Гүйцэтгэлийг байгууллагын төрлөөр ангилж үзэхэд

сая төгрөгөөр

| Байгууллага | 2021 оны | | Зөрүү /хэмнэлт, хэтрэлт/ |
|--|-----------------|-----------------|--------------------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| Аймгийн шууд | 12,839.6 | 12,170.7 | -668.9 |
| ИТХ | 1,003.3 | 998.3 | -5.0 |
| ЗДТГ | 5,913.3 | 5,870.9 | -42.4 |
| ОНХС | 3,134.8 | 2,736.1 | -398.7 |
| ХТА | 219.5 | 219.5 | 0.0 |
| СХС | 1,320.4 | 653.5 | -666.9 |
| Соёлын төв | 1,196.0 | 1,188.8 | -7.2 |
| БОХСан | 14.6 | 8.8 | -5.8 |
| ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 4,347.7 | 4,330.9 | -16.8 |
| Дүн | 29,989.2 | 28,114.4 | -1,811.8 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал:

Хүснэгт №15 Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт
сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү |
|--|-----------|---------|----------|
| Орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл | 26,608.40 | 28177.4 | 1,569.00 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх онтой харьцуулахад орон нутгийн төсвийн суурь зарлагын гүйцэтгэл 1,569.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Орон нутгийн төсөвт байгууллагууд оны эцэст аймаг, сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд 76.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тухайлбал: Аймгийн төсвөөс шууд санхүүжидэг байгууллагууд 17.2 сая, сумууд 59.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.2 Аймгийн Орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл 99.6 хувь, зарлагын гүйцэтгэл 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна

2.2.1 Орон нутгийн нийт төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн нийт төсвийн орлогын гүйцэтгэл 99.9 хувтай биелэгдсэн байна.

Хүснэгт №16 Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн орлогын бүтэц

сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2020 оны нийт орлого, эх үүсвэр | 2021 оны төсвийн орлогын | | | |
|---|---------------------------------|--------------------------|-----------------|--------------|--------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Татварын орлого | 10301.3 | 10808.5 | 11932.4 | 1123.9 | 110.4% |
| Татварын бус орлого | 943.7 | 1250.7 | 1472.4 | 221.7 | 117.7% |
| Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 7642.1 | 6451.8 | 6451.8 | 0 | 100.0% |
| Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг | 5927.8 | 8360.3 | 8360.3 | 0 | 100.0% |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 67832 | 67213.8 | 66926.8 | -287 | 99.6% |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 316.8 | 513 | 419.4 | -93.6 | 81.8% |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 513.9 | 1425.8 | 1306.2 | -119.6 | 93.3% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос | | | 31.9 | 31.9 | |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1182.7 | 1542.2 | 749.8 | -792.4 | 48.6% |
| Төсвийн шилжих үлдэгдэл | | 149.8 | | -149.8 | 0.0 |
| Нийт орлогын дүн | 94660.3 | 97715.9 | 97,651.0 | -64.9 | 99.96 |

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт орлого, тусламж, эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөө 97,715.9 сая төгрөг байна. Гүйцэтгэлээр нийтдээ 97,651.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 0.04 хувь бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвөөс авсан санхүүжилтээс оны эцэст тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нийтдээ 286.9 сая төгрөгийг, орон нутгийн төсвийн байгууллагууд 76.7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийг задалж авч үзвэл:

- Тусгай зориулалтын шилжүүлгээс нийтдээ 67,213.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 286.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
- Орон нутгийн төсвийн суурь орлогын гүйцэтгэлээр нийтдээ 13,404.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 1,345.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.
- Улсын төсвөөс 6,451.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр 8,360.3 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 513.0 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр 93.6 сая төгрөгөөр дутуу буюу 419.4 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,425.8 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр 1,306.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 31.9 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөснөөс 87.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан.
- Төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих дүнг 1,692.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 749.2 сая төгрөгийг зарцуулж 942.2 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсөвт буцаан төвлөрүүлсэн санхүүжилтийг хасаж, мөнгөний эхний үлдэгдлийг нэмж тооцоход гүйцэтгэлээр нийтдээ 97,651.0 сая төгрөгийн орлого, эх үүсвэр бүрдүүлсэн байна.

2.2.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс 2,192.3 сая төгрөгөөр бага буюу 97.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймгийн 2021 оны оны нэгдсэн төсвийн зарлагын батлагдсан нийт төлөвлөгөө 97,715.8 сая төгрөг ба гүйцэтгэлээр 95,523.5 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, төлөвлөснөөс 2,192.3 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №17 Нийт төсвийн зарлагын гүйцэтгэл

| Үзүүлэлт | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны | | | Зөрүү /3-2/ | Зөрүү гүйцэтгэл /3-1/ |
|---|-----------------------|----------------|----------------|----------------|----------------|-----------------------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | | |
| А | 1 | 2 | 3 | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 88446.4 | 97715.8 | 95523.5 | -2192.3 | 7077.1 | |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 83054.9 | 89199.4 | 87989.9 | -1209.5 | 4935.0 | |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 80574 | 85862.3 | 84707.7 | -1154.6 | 4133.7 | |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 55694.2 | 60082.9 | 59929.2 | -153.7 | 4235 | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7404.5 | 8104.8 | 8037.9 | -66.9 | 633.4 | |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5613.5 | 5625.2 | 5608.9 | -16.3 | -4.6 | |
| Хангамж, бараа материалын зардал | 1418.4 | 1444.9 | 1437.2 | -7.7 | 18.8 | |
| Нормативт зардал | 5173.4 | 3434.9 | 3292.8 | -142.1 | -1880.6 | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 168 | 686 | 683.4 | -2.6 | 515.4 | |
| Томилолт, зочны зардал | 128.6 | 166.6 | 161.1 | -5.5 | 32.5 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 922.4 | 933.9 | 928.5 | -5.4 | 6.1 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4051 | 5383.1 | 4628.7 | -754.4 | 577.7 | |
| Татаас | 1376.6 | 1348.6 | 1342.4 | -6.2 | -34.2 | |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 1376.6 | 1348.6 | 1342.4 | -6.2 | -34.2 | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1104.3 | 1988.5 | 1939.8 | -48.7 | 835.5 | |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5391.5 | 8516.4 | 7533.6 | -982.8 | 2142.1 | |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 88194.2 | 97715.9 | 96736.1 | -979.8 | 8541.9 | |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 63161.7 | 67726.8 | 67346.2 | -380.6 | 4184.5 | |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 62844.9 | 67213.8 | 66926.8 | -287 | 4081.9 | |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 316.8 | 513 | 419.4 | -93.6 | 102.6 | |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 24518.6 | 27021.1 | 27963.7 | 942.6 | 3445.1 | |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 18590.8 | 18660.8 | 19603.4 | 942.6 | 1012.6 | |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 5927.8 | 8360.3 | 8360.3 | 0 | 2432.5 | |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 513.9 | 1425.8 | 1426.2 | 0.4 | 912.3 | |
| | | 1542.2 | | -1542.2 | 0 | |
| Мөнгөний эхний үлдэгдэл | 1182.7 | | 914.9 | | | |
| Мөнгөний эцсийн үлдэгдэл | 930.6 | | 2127.4 | | | |

Эх сурвалж: Аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийт зарлагын 84,707.7 сая төгрөгийг буюу 88.6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 1,939.8 сая төгрөгийг буюу 2 хувийг урсгал шилжүүлэгт, 1,342.4 сая төгрөгийг буюу 1.4 хувийг татаас, 7,533.6 сая төгрөгийг буюу 7.9 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөвтэй харьцуулахад бараа үйлчилгээний зардал 1,154.6 сая, дотоодын хөрөнгө оруулалт 982.8 сая, урсгал шилжүүлэг 48.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Тайлант оны зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад цалин, НДШ-ийн зардал 4,868.4 сая, хангамж бараа материалын зардал 18.8 сая, эд хогшил, урсгал засварын зардал 515.4 сая, томилолт, зочны зардал 32.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 6.1 сая, бараа үйлчилгээний бусад зардал 577.7 сая, урсгал шилжүүлэг 835.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 4.6 сая,

нормативт зардал 1,880.6 сая, татаас 34.2 сая төгрөгөөр тус тус бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зарлагын 23,840.7 сая төгрөгийг буюу 24.9 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын, 71,677.0 сая төгрөгийг буюу 65.1 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага эзэлж байна.

Хүснэгт №18 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгуулгаар харуулбал

| № | Байгууллага | 2021 оны | | Зөрүү |
|----------|---|-----------------|-----------------|-----------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 1 | ТЗШ-ийн байгууллагуудын дүн | 72,074.4 | 71,677.0 | -397.3 |
| | Ерөнхий боловсролын байгууллагууд | 44,969.9 | 44,855.6 | -114.3 |
| | СӨБ-ын байгууллагууд | 16,785.2 | 16,598.4 | -186.8 |
| | Эрүүл мэндийн байгууллагууд | 9,605.8 | 9,510.3 | -95.5 |
| | Гэр бүл, ХЗХөгжлийн газар | 244.8 | 244.1 | -0.7 |
| | ГХБХБГазар | 468.7 | 468.6 | -0.1 |
| 2 | Орон нутгийн төсвийн байгууллагууд | 25,641.5 | 23,840.7 | -1,800.7 |
| | Орон нутгийн хөгжлийн сан | 8,516.4 | 7,533.6 | -982.8 |
| | Сум хөгжүүлэх сан | 1,320.4 | 653.5 | -666.9 |
| | БОХСан | 14.6 | 8.8 | -11.6 |
| | Сумуудын ЗДТГ | 5,913.3 | 5,870.9 | -42.4 |
| | Сумуудын ИТХ | 1,003.3 | 998.3 | -5.0 |
| | Соёлын төв | 1,196.0 | 1,188.8 | -7.2 |
| | Аймгийн шууд | 7,677.5 | 7,592.6 | -84.9 |
| | ДҮН | 97,715.8 | 95,523.5 | -2,192.3 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгээр аймгийн Засаг даргад аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан орон тооны хязгаарыг 306 хүнээр хэтрүүлсэн, тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг 19 байгууллага 42.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай, 9 байгууллага халаалтын зардалд нийт 424.0 сая төгрөгийн өглөгтэй, үүнээс 363.4 сая төгрөгийн он дамжсан өглөгтэй, 2020 оны эцэст 90 төсөвт байгууллага нийтдээ 970.5 сая төгрөгийн өглөгтэй гарч өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байсан зөрчлийн дүнгээр албан шаардлага өгөгдсөн.

Албан шаардлагын биелэлтийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 5-03/408 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Биелэлтийг давтан шалгахад Орон нутгийн төсвийн байгууллагуудын авлага 714.8 сая төгрөгөөр, өр төлбөр 4.5 сая төгрөгөөр буурсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын авлага 531.1 сая төгрөгөөр, өр төлбөр 223.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг дутуу авсан, төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг үндэслэлгүй бууруулж төлөвлөж ирснээс эдгээр байгууллагуудын он дамжсан өглөг нэмэгдэж халаалтын өр 672.8 сая төгрөгт хүрсэн байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудын өр төлбөр жилийн эцэст нийтдээ 1,362.4 сая төгрөгт хүрч оны эхнээс нэмэгдсэн байна.

Төсөвт байгууллагуудын халаалтын өр өмнөх оноос нэмэгдсэн, орон тооны хязгаарыг 252 хүнээр хэтрүүлж албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 88.4 хувьтай байна

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,161.2 сая, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 199.1 сая, нийт 8.360.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үүнээс 358.6 сая төгрөгийг урсгал зардалд баталсан төсөв ба малын эмч нарын вакцинжуулалтын хөлсөнд 337.1 сая, Хот тохижуулах газрын нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээнд 21.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгосон орлогын шилжүүлгийн 8,001.7 сая төгрөг болон аймаг, сумын ИТХ ын тогтоолоор урьд оны үлдэгдлээс тодотгож баталсан 514.6 сая төгрөг, нийт 8516.4 төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж гүйцэтгэлээр 7,533.6 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Аймгийн ОНХСангийн батлагдсан төлөвлөгөө 5,381.6 сая, гүйцэтгэл 4,797.5 сая төгрөг байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 5,381.6 сая төгрөгийн 169 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 4,789.9 сая төгрөгийн 159 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас 289.6 сая төгрөгийг дутуу зарцуулсан ба зураг төсөв болон бусад гүйцэтгэлийн дутуу санхүүжилт 87.9 сая төгрөг байна. Төлөвлөсөн 169 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл, арга хэмжээ тухайн онд хэрэгжээгүй байна.

Сумуудын ОНХСангуудын батлагдсан төлөвлөгөө 3,134.7 сая, гүйцэтгэл 2,736.1 сая төгрөг байна.

Хүснэгт№ 19 Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

сая төгрөгөөр

| № | Байгууллагын нэр | 2021 оны | | Зөрүү /хэмнэлт, хэтрэлт/ |
|---|------------------|------------|-----------|--------------------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 1 | Алтай | 163.0 | 152.5 | (10.4) |
| 2 | Алтанцөгц | 125.9 | 110.7 | (15.2) |
| 3 | Баяннуур | 134.1 | 63.9 | (70.2) |
| 4 | Бугат | 125.5 | 112.9 | (12.6) |

| | | | | |
|------------|------------|-----------------|-----------------|---------------|
| 5 | Булган | 454.9 | 416.4 | (38.5) |
| 6 | Буянт | 124.7 | 94.7 | (30.1) |
| 7 | Дэлүүн | 293.9 | 293.9 | - |
| 8 | Ногооннуур | 341.6 | 307.3 | (34.4) |
| 9 | Сагсай | 175.3 | 98.2 | (77.1) |
| 10 | Толбо | 144.8 | 121.2 | (23.5) |
| 11 | Улаанхус | 214.6 | 212.4 | (2.2) |
| 12 | Цагаануур | 50.0 | 50.0 | (0.0) |
| 13 | Цэнгэл | 428.5 | 351.2 | (77.3) |
| 14 | Өлгий | 357.9 | 350.6 | (7.3) |
| ДҮН | | 3,134.76 | 2,736.07 | -398.7 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Замын сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зам засварын ажилд 2021 онд 315.0 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 21 төсөл арга хэмжээнд 279.2 сая төгрөгийн ажлын гэрээ хийгдсэн байна.

Төлөвлөсөн ажлаас Цэнгэл сумын Арал толгой застав, Давааны хаяа уулын замын эхлэлээс Цагаан голын рашаан хүртэлх замын засварын ажил, Цэнгэл Арал толгой застав Цагаан голын рашаан замын эхлэлээс Даваа хүртэлх замын засварын 28.0 сая төгрөгийн 2 ажлын санхүүжилтээс бусад ажлын санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.2.4 Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийн талаар

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв 99.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд нийтдээ 67,726.8 сая төгрөгийн төсөв батлагдсан ба гүйцэтгэл 67,346.2 сая төгрөг байна.

Хүснэгт №20 Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэл

| Үзүүлэлт | 2021 он | | Зөрүү |
|--|----------------|----------------|---------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 67726.8 | 67346.2 | -380.6 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 67726.8 | 67346.2 | -380.6 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 65041.8 | 64713.3 | -328.5 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 51609.5 | 51491.4 | -118.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6976.3 | 6920.4 | -55.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 995.4 | 989.3 | -6.1 |
| Нормативт зардал | 3242.8 | 3100.8 | -142.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 462.5 | 462.5 | 0.1 |
| Томилолт, зочны зардал | 58.7 | 55.6 | -3.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 183.2 | 180.5 | -2.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1513.5 | 1512.8 | -0.7 |
| Татаас | 1348.6 | 1342.4 | -6.2 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 1348.6 | 1342.4 | -6.2 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1336.4 | 1290.5 | -45.9 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 67726.8 | 67346.2 | -380.7 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 67213.8 | 66926.8 | -287.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 67,213.8 | 66,926.8 | -287.0 |

| | | | |
|---|--------------|--------------|--------------|
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.0 | 0.0 | 0.0 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | | | 0.0 |
| НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 513.0 | 419.4 | -93.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 513.0 | 419.4 | -93.6 |
| Мөнгөний эхний үлдэгдэл | | 0.0 | 0.0 |
| Мөнгөний эцсийн үлдэгдэл | | 4.0 | 4.0 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 67,213.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 513.0 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 67,726.8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж төлөвлөснөөс 380.6 сая төгрөгөөр бага зардал гаргасан байна.

Цалингийн зардал 118.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 55.9 сая, нормативт зардал 142.0 сая, урсгал шилжүүлэг 45.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байгаа нь Эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг дутуу авсан, зарим төсөвт байгууллагууд 287.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2.2.5 Аймгийн ТЕЗ-ийн орон тооны гүйцэтгэлийн талаар

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан орон тооны хязгаарыг 242 хүнээр хэтрүүлсэн байна

Аймгийн ИТХ-ын 2021 оны төсөв баталсан 2020 оны 16 дугаар тогтоол, төсвийг тодотгосон 2021 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар төсөвт байгууллагуудын 2021 оны орон тооны хязгаарыг 5260 хүнээр баталсан байна.

Төсөвт байгууллагуудад гүйцэтгэлээр нийтдээ 5502 хүн ажиллуулж орон тооны хязгаарыг 242 хүнээр хэтрүүлсэн байна.

Хүснэгт №21 Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл

| № | Байгууллагууд | Өмнөх оны гүйцэтгэл | Ажиллагсдын тоо | | | | | | |
|---------|----------------------------|---------------------|-----------------|-------------|------------|------------|-------------|-------------|------------|
| | | | 2021 оны | | | | | | |
| | | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Үүнээс: | | | |
| Удирдах | Гүйцэтгэх | Үйлчлэх | | | | Гэрээт | | | |
| 1 | ТЗШ-ийн байгууллагууд | 4394 | 4457 | 4664 | 214 | 111 | 2766 | 1562 | 225 |
| 2 | Орон нутгийн байгууллагууд | 822 | 803 | 838 | 38 | 184 | 393 | 199 | 62 |
| | Бүгд | 5216 | 5260 | 5502 | 252 | 295 | 3159 | 1761 | 287 |

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлангаар

Орон нутгийн төсөвт байгууллагуудын батлагдсан орон тооны хязгаар 803 ба гүйцэтгэлээр 838 хүн ажиллуулж орон тооны хязгаарыг 35-аар хэтрүүлжээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад орон тооны хязгаарыг 4457-аар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4664 хүн ажилуулж 207-гоор хэтрүүлсэн байна.

Дээрх байдлаар орон тооны хязгаарыг хэтрүүлэн ажиллуулж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, зохицуулж ирсэн байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой ямар нэг шийдвэрийг гараагүй байна.

2.3 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Аймгийн ТЕЗ-ийн харъяа төсвийн байгууллагууд 2021 онд 3,099.2 сая төгрөгийн нэмэлт төсөв авч, үйл ажиллагаандаа зарцуулсан байна

Орон нутгийн төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд оны эхэнд 12.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 3,091.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үйл ажиллагаандаа 3,099.2 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 4.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна. Оны эхний үлдэгдлээс 7.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 2,281.6 сая төгрөгийг буюу 73.8 хувийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс, 137.6 сая төгрөгийг буюу 4.4 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн этгээдээс авсан хандив тусламжаас, 545.1 сая төгрөгийг буюу 17.6 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос, 42.8 сая төгрөгийг буюу 1.3 хувийг ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс хуваарилсан хөрөнгөөс хүлээн авсан байна.

Хүснэгт №22 Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|-----------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,099.20 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 3,099.20 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,285.20 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 619 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 68.1 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39.7 |
| Хангамж, бараа материалын зардал | 173 |
| Нормативт зардал | 253.2 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 63.8 |
| Томиллолт, зочны зардал | 16.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,029.80 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 641.1 |
| Бусад урсгал шилжүүлэг | 569.1 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 72 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 172.9 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,091.30 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,091.30 |
| Төрийн болон орон нутгийн өмчийн этгээдээс авсан хандив тусламж | 137.6 |
| ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42.8 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2281.6 |

| | |
|--|-------------|
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 545.1 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 84.2 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 7.90 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12.3 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4.40 |

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн 33.2 хувийг буюу 1,029.8 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 22.1 хувийг буюу 687.1 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 18.3 хувийг буюу 569.1 сая төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт, 24.1 хувийг бусад зардалд зарцуулж 72.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бүлэг 3. Хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилтийг тайлагнах ажил хангалтгүй байна.

3. ТЕЗ-ИЙН 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилтийг тайлагнах ажил хангалтгүй байна

3.1 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний төлөвлөлт

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 38 арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшнийг төлөвлөсөн байна

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны “Баян-Өлгий аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, түүнд хамаарах 38 арга хэмжээ баталсан байна. Үүнд:

-Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөр буюу аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд хамаарах 4 арга хэмжээ,

-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 19 арга хэмжээ, улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх 15 арга хэмжээ баталсан байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөрт аймгийн ИТХ-ын байгууллагын үйл ажиллагаа, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай харилцаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болон аймгийн хэмжээнд өөрийн удирдлага хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг, зөвлөн туслах ажлууд хамрагдаж байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, хяналт, шинжилгээ, ахмад настны нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, ойжуулалтын ажиллагаа, мал эмнэлгийн үйлчилгээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн хүрэх үр дүнг төлөвлөсөн байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх ерөнхий болон сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа, албан бус боловсрол олгох үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, соёл урлагийн салбар, нийтийн биеийн тамир, газрын харилцаа, кадастрын үйлчилгээ, хүүхдийн хөгжил, хамгааллын

үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөж, хүрэх үр дүнг баталсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй байна. Тухайлбал: Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг балансын дансны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын тухайн онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулж, хүрэх үр дүн, зорилтот түвшин, зарцуулах төсөв, чанарын үзүүлэлтийг бодитой тусгаж төлөвлөөгүй байна.

3.2 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилт

Хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний үзүүлэлтийн дагуу чанарын болон тоон үзүүлэлттэй харьцуулж бодит хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөр буюу аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд хамаарах 4 арга хэмжээний биелэлтийн талаар

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа зарлан хуралдуулж тэргүүлэгчдийн ирцийг бүрдүүлж шийдвэрийн биелэлтэнд хяналт тавихаар төлөвлөсөний дагуу 2021 онд ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 2 удаа хуралдаж, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны Үндсэн чиглэлийг баталсан байна. Үндсэн чиглэлийг боловсруулахдаа аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 4 жилийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан 2021 онд зайлшгүй хэрэгжүүлэх асуудлууд, 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан хэдий ч эдийн засаг, санхүүгийн байдлаас шалтгаалан бүрэн биелэгдээгүй зарим нэг зүйл заалтуудыг дахин төлөвлөлтөд оруулж гүйцэтгэлийг хангах зарчмыг баримтлан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж тусгасан ба энэ тогтоол бүрэн хэрэгжсэн байна.

Олон нийт, байгууллага, аж ахуйн нэгж, ТББ-дай харилцаж санал хүсэлт, өргөдөл гомдлыг тухайн үед шийдвэрлэн хариу өгч ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүрэх түвшний үзүүлэлт нь гэмт хэргийн тоо 20 хувиар буурсан байхаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр гэмт хэргийн 50-60 хувийг эзэлдэг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зөв оновчтой, зорилтод бүлэгт хүргэж зохион байгуулсны үр дүнд хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 хэргээр буюу 16.8 хувиар, хулгайлах гэмт хэрэг 18 хэргээр буюу 33.3 хувиар буурсан байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах арга хэмжээний гүйцэтгэлийн талаар

ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, заавар журамтай нийцүүлэн ил тод, иргэдийн саналыг авсны үндсэн дээр аймгийн хөгжлийн хөтөлбөртэй

уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл 89 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Бугат сумд тэжээлийн нөөц бүрдүүлэх ажил 8.0 сая, Өлгий сумын 5 дугаар багийн зам засварын 20.0 сая, Дэлүүн сумын 10 дугаар багийн худгийг цахилгааны эх үүсвэрт холбох 20.0 сая, Өлгий сумын 10 дугаар багт трансформатор тавьж айл өрхүүдийг цахилгаанд холбох 30.0 сая, Дэлүүн сумын 7 дугаар багийн өвөлжөөнд гүний худаг гаргах 9.8 сая, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шинжилгээний анализатор нийлүүлэх 40.5 сая, Баяннуур сумын Эрүүл мэндийн төвд биохимийн анализатор нийлүүлэх 14.5 сая, Бугат сумын гэрэлтүүлгийн цахилгаан болон арчилгааны 7.4 сая, Багш нарын спортын арга хэмжээний 5.0 сая, аймгийн Мал эмнэлгийн газарт мал амьтны халдварт шимэгч өвчинтэй тэмцэх, хортон шавьжийг устгахад олгох 50.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээнүүд тайлант онд хэрэгжээгүй байна.

Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн 87.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бусад төлөвлөсөн арга, хэмжээ хэрэгжсэн талаар биелэлтийг ирүүлэхдээ төлөвлөсөн хүрэх үр дүнгийн /чанарын болон тоон/ үзүүлэлттэй харьцуулж, бодит гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан хөтөлбөр, арга хэмжээ, төсвийн орлого, зарлагын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга/хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсний дагуу танилцуулга, тайлбар, тодруулга ирүүлээгүй болно.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Баян-Өлгий аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас 4,901.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
2. Баян-Өлгий аймгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,228.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
3. Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг 1,345.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.
4. Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл 99.6 хувийн, зарлагын гүйцэтгэл 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.
5. Орон нутгийн төсвийн байгууллагуудын өр төлбөр жилийн эцэст 1,362.4 сая төгрөгт хүрч оны эхнээс нэмэгдсэн байна.
6. Аймгийн ТЕЗ-ийн харъяа төсвийн байгууллагууд 2021 онд 3,099.2 сая төгрөгийн нэмэлт төсөв авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна
7. Хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилтийг тайлагнах ажил хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН ТАНАА:

1. Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг балансын дансны хөтөлбөр, аймгийн Засаг даргын тухайн онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулж, хүрэх зорилтот түвшин, зарцуулах төсөв, чанарын үзүүлэлтийг үнэн зөв тусгаж төлөвлөх, хүрсэн үр дүн, гүйцэтгэлийг чанарын болон тоон үзүүлэлттэй харьцуулан гаргаж танилцуулга, тайлбар, дүгнэлтийг Аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт ирүүлж хэвших;
2. Төсөвт байгууллагуудын халаалтын он дамжсан өр төлбөр нэмэгдсэн, батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлсэн зөрчлүүд давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг үндэслэлтэй хийх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах талаар тодорхой арга хэмжээ авах;



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/05

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 2.1, 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Т.Фестивал/ нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



D:\bichig hereg\2022\tushaal.doc